

ХОВД АЙМГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ ШИЙДВЭР, ТАЙЛАН МЭДЭЭ ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТНИЙ
2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Биеийн тамирын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх /эрүүл мэндээ хамгаалах, сайжируулах/ нөхцөлийг бүрдүүлж олон нийтэд хүртээмжтэй болгох							
1	Зорилт 1 Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах		Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоо бүрдэх	Биеийн тамир, өдөрлөгийн арга хэмжээ-60, сорил хүн амын 123, спорт заал-37 мэдээллийн сан-100%	Биеийн тамир, өдөрлөгийн арга хэмжээ-65, сорил хүн амын 15%, спорт заал-39 мэдээллийн сан-100%	“Цаг гаргая” аяныг зохион байгуулж, 17 сум, 91 багийн иргэд, 90 гаруй албан байгууллагын албан хаагчдын дунд өглөөний дасгал, алхалт, гүйлт, дугуй, хийн дасгал, ажлын байрны дасгал зэрэг арга хэмжээнд давхардсан тоогоор 54240 гаруй иргэнийг оролцуулсан, “Эв нэгдэл спортоор манлайлья” аяныг орон нутагтаа эхлүүлж аймгийн Засаг даргын захирамжаар бүх төрийн өмчийн байгууллагуудын спорт заалыг 7 хоног бүрийн 5 дахь өдрийн орой 18-21 цагийн хооронд үнэ төлбөргүй нээлттэй болгон иргэдэд дасгал	94,6

						хөдөлгөөнөөр хичээллэх боломжийг бүрдүүлээ. Ингэснээр зааланд тоглох, биеийн тамираар хичээллэх иргэдийн тоо 23760 болон өсч 70 хувиар нэмэгдсэн. Аймгийн нийт иргэдийн 13.5 хувь буюу 14758 сорилд хамрагдсан байна.	
1.1	Арга хэмжээ 1: Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилыг хугацаанд нь авч шивэх	Улсын төсөв 5 сая	Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар) сорилд хамрагдсан А, В, С үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулж 100-гаар үржүүлнэ хувиар тооцно	2023 онд аймгийн хэмжээнд 9763 иргэн сорилд хамрагдаж нийт сорилд хамрагдсан иргэдийн 47,9 хувь нь А, В, С үнэлгээ авсан байна. Сумууд болон төрийн байгууллагуудын нийт ажилчдын 20 хувиас бие бялдрын сорилыг авч нэгдсэн санд бүртгүүлсэн.	2024 онд 48 хувьд	2024 онд 17 сум, 69 байгууллагын 14758 иргэнээс сорил авсан байна. Хамрагдсан иргэдийг үнэлүүлэхэд: 2210-А, 3373-В, 1536-С үнэлгээ авсан байна. Аймгийн нийт иргэдийн 13.5 хувь буюу 14758 сорилд хамрагдсан байна. Сумууд болон төрийн байгууллагуудын нийт ажилчдын 20 хувиас бие бялдрын сорилыг авч нэгдсэн санд бүртгүүлсэн. Иргэдийн 30 гаруй хувь нь илүүдэл жинтэй гарч байна.	100
1.2	Арга хэмжээ 2 Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлэх	-	17 сумуудад орон тооны бус биеийн тамирын арга зүйчтэй болгосон байна.	2023 онд Эрдэнэбүрэн, Булган, Манхан сумууд орон	Орон тооны арга зүйч-6, 16 суманд орон тооны бус арга зүйчтэй болох	Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар бүлэг 8.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Ховд аймгийн 17 сумаас	70

				тооны арга зүйчтэй болсон.		Эрдэнэбүрэн, Манхан, Мянгад, Жаргалант, Булган суманд орон тооны арга зүйчтэй болсон. Бусад сумууд хавсаргах байдлаар орон тооны бус арга зүйчийг ажиллуулж байна. Сумдад арга зүйчийн орон тоонд мэргэжлийн боловсон хүчинг нээлттэй зарлаж сонгон шалгаруулж ажиллуулах чиглэлийг аймгийн Засаг даргаар хүргүүлэн ажиллаж байна. Сумын биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах, тухайн сумын биеийн тамир спортын судалгааг үнэн зөв тодорхойлсноор спорт хөгжих боломж бүрдэж байна. Сумын аварга шалгаруулах тэмцээнүүд, иргэдийн бие бялдрын сорилууд цаг хугацаандаа хийгдэж байна.	
1.3	Арга хэмжээ 3 Байгууллагын мэдээллийн цахим санг бүрдүүлж зарим мэдээллийг цахимаар авах боломжийг бүрдүүлнэ.	Улсын төсөв 1 сая	Мэдээллийн сангийн үйл ажиллагаа эхэлж ажил, үйлчилгээг цахимаар үзүүлдэг болсон байна.	-	2024 онд Мэдээллийн сангийн үйл ажиллагаа явуулах	Мэдээллийн цахим санг хөгжүүлэх мэдээ мэдээлэл байршуулах арга хэмжээг тогтмол зохион байгууллаа. 64 арга хэмжээний мэдээ, мэдээлэл байршуулсан. Мэдээлэл	100

						байршуулснаар ард иргэд мэдээлэл авч үйлчлүүлэх иргэд спортоор хичээллэх хүүхдийн тоо 20 хувиар нэмэгдлээ.	
1.4	Арга хэмжээ 4 Биеийн тамир, спортын холбоодын мэдээллийг цахим санд бүртгэн мэдээллийг байршуулах /холбоод, клубын мэдээлэл/	Улсын төсөв 1 сая	Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санд спортын холбоодын үйл ажиллагаатай холбоотой эх өгөгдөл байршсан байна.	-	2021-2024 онд 23 спортын холбоо	Цахим санд байршуулах мэдээ мэдээлэл цуглуулах бэлтгэх сан бүрдүүлэх талаар спортын холбоодод албан бичиг хүргүүлэн уулзалт зохион байгуулж үйл ажиллагааг эхлүүлсэн.	90
1.5	Арга хэмжээ 5 Алтай, Зэрэг, Цэцэг, Дарви сум, Жаргалант сумын Бугат багийн спорт заалыг ашиглалтад оруулах	Улсын төсөв 6,3 тэрбум	Алтай, Зэрэг, Цэцэг, Дарви суманд Жаргалант сумын Бугат, Хайрхан багт спорт заал шинээр барина.	Барилга угсралтын ажил явагдаж байна.	2024 онд ашиглалтанд оруулах	Алтай, Зэрэг, Цэцэг, Дарви сумын спорт заал баригдаж байна. 2023 оны 9 сард Зэрэг сумын заалыг ашиглалтад хүлээн авлаа. 2024 онд Жаргалант сумын Бугат, хайрхан багийн заалыг комисс хүлээн авч үйл ажиллагаа эхэлсэн байна. Цэцэг сум, Дарви сум, Алтай сумын спорт заал баригдаж байна. Спорт заалны барилгын гүйцэтгэл Дарви-50%, Цэцэг-60%, Алтай сум-30%-тай барилгын ажил явагдаж байна.	70
1.6	Арга хэмжээ 6	Улсын төсөв 3 сая	Ахмад насны иргэдийг спортын	Спортын арга хэмжээ-2	Спортын арга хэмжээ -3	“Цаг гаргая”, “Эв нэгдэл спортоор манлайлъя” аяны	100

	Ахмад настны спортын үйл ажиллагаанд хамруулах, дэмжлэг үзүүлэх		үйл ажиллагааг нэмэгдүүлэх тоо			хүрээнд ахмадуудыг өглөөний алхалт, хийн дасгал, шугаман бүжгийг Ард аюушийн талбай болон Спортын ордонд тогтмол хийлгэж хэвшсэн байна. 120 гаруй ахмад тогтмол хийн дасгал, шугаман бүжиг хийж өглөөний алхалтанд хамрагдаж байна. Ахмадын сарын аяны хүрээнд Ховд хотын Ахмадуудын дунд спортлог эрүүл ахмад өдөрлөгийг амжилттай зохион байгуулж сорил, эрүүл мэндийн үзлэг, ширээний шагай, хийн дасгал, 32 тоот дасгал, олс таталт, буухиа зэрэг арга хэмжээг зохион байгуулж 300 гаруй ахмадууд оролцсон.	
1.7	Арга хэмжээ 7 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, дэмжлэг үзүүлэх	Улсын төсөв 3 сая	Спортын арга хэмжээнд хамрагддаг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нэмэгдүүлнэ.	Спортын арга хэмжээнд оролцох хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо-250	2023 онд 5 хувиар нэмэгдүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ширээний теннис, сагсан бөмбөг, хөнгөн атлетик, волейбол, жүдо бөхийн төрлүүдээр 40 гаруй иргэн тогтмол хичээллэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сарын аяны хүрээнд спортын 8 арга	100

						хэмжээг 250 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Ази номхон далайн орнууд зүүн Азийн сагсан бөмбөгийн тэмцээн манай аймгийн 1 тамирчин оролцож хүрэл медаль хүртсэн байна.	
1.8	Арга хэмжээ 8 Өртөөт марафон -2024 Бүх нийтийн арга хэмжээг зохион байгуулах	Орон нутгийн төсөв 4 сая	“Өртөөт марафон-2024” Бүх нийтийн арга хэмжээг зохион байгуулна.	2023 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтарч Өртөөт марафон бүх нийтийн гүйлтийн арга хэмжээг 200 гаруй иргэний дунд зохион байгууллаа. Эрэгтэй төрөл 5 км-ийн зайд 120 иргэн оролцож Д.Буянхишиг түрүүлсэн. Эмэгтэй 3 км-ийн зайд зохион байгуулагдлаа.	55 гаруй байгууллагыг оролцуулж 350 гаруй хүн хамруулах	5 сард эмнэлгийн салбарын байгууллагуудын дунд зохион байгуулж 300 гаруй албан хаагчид оролцлоо. 9 дүгээр сард боловсролын салбар буюу сургуулийн намрын спартакиадууд оруулан зохион байгууллаа. 7 сургуулийн 1500 гаруй сурагчид оролцсон. Хүүхдүүдийн бие бялдрын хөгжил, хүмүүжил, багаар ажиллах чадварыг бий болгоход чухал үр дүнтэй.	100
1.9	Арга хэмжээ 9	Улсын төсөв 7 сая	Нийтийн биеийн тамирын аян эхлүүлнэ.	Монгол Улсын Ерөнхий сайдын санаачлагаар улс орон даяар “Илүүдэл жингүй –Эртэч монгол”	Өглөөний дасгал , алхалт, гүйлтийг 4 чиглэлд, хийн дасгалыг талбай дээр болон спортын	“Цаг гаргая” “Эв нэгдэл спортоор манлайлъя” аяны арга хэмжээнүүдэд 17 сумын иргэд, 90 гаруй төрийн болон төрийн бус байгууллагын албан	100

	<p>Нийтийн биеийн тамирын Өглөөлөг-Ховдчууд аян зохион байгуулах</p>			<p>Цаг гаргая аянд иргэдийг хамруулсан</p>	<p>ордонд зохион байгуулах</p>	<p>хаагчдын төлөөлөл 78 мянган хүн 9 сар гаруй хугацаанд өглөөний дасгал, алхалт, гүйлт, дугуй, шугман бүжиг, хийн дасгалд тогтмол хамрагдаж, ажилтан албан хаагчид ажлын байрны дасгалуудыг хийж хэвшсэн.</p> <p>Өргөөт марафон, иргэдийн наадам, хөгжөөнт буухиа зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулагдлаа. Эрүүл чийрэг, бүтээлч зан чанарыг эрхэмлэн өдөр тутмын дасгал хөдөлгөөн, зөв хооллолт, эрүүл амьдралын хэв маягийн талаар орон нутагт түгээх олон талт арга хэмжээг спортын клубуудтай хамтран тогтмол зохион байгуулж байна.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу авдаг жил бүрийн хавар, намрын бие бялдрын сорилд 14758 хүнийг хамруулсан байна.</p> <p>Аймгийн хэмжээнд нийтийн биеийн</p>	
--	--	--	--	--	------------------------------------	--	--

						тамирын арга хэмжээнд иргэдийн оролцоо өмнөх оноос 70 хувиар нэмэгдсэн байна.	
1.10	Арга хэмжээ 10 “Иргэдийн наадам” биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах	Орон нутгийн төсөв 10 сая	Хамрагдсан байгууллага, хүний тоо	Иргэдийн наадам-2023 биеийн тамирын арга хэмжээ амжилттай зохион байгуулагдлаа. Уг тэмцээн нь иргэдийг биеийн тамирын дасгал, хөдөлгөөний дутагдалаас урьдчилан сэргийлэх, биеийн дархлааг дэмжих, эрүүл амьдрах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн уг тэмцээн нь Сагсан бөмбөг, Пауэрлифтинг, ширээний шагай, Волейбол, олс таталт, хөгжөөнт буухиа, байт харваа, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрлөгөөр 4 спортын арга хэмжээ нийтдээ спортын 12 төрлөөр 5000	Иргэдийн наадмын анхан болон шигшээ арга хэмжээг зохион байгуулах	Иргэдийг спортоор хичээллэх идэвхи санаачлага, бие бялдарын боловсрол олгох, оюун ухаан сэтгэн бодох чадварыг нь хөгжүүлэх, урам зоригийг нь нэмэгдүүлэх, спортын ур чадварыг нь дээшлүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, авъяастай ирээдүйтэй тамирчдыг нээн илрүүлж спортоор хичээллэгчдийн тоог өсгөх, баг хамт олны багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Иргэдийн спортын наадам”-ыг Ховд хотноо зохион байгууллаа. Тус наадамд Шугаман бүжиг, Ширээний шагай, Шатар, Ширээний теннис, Буухиа зэрэг спортын таван төрлөөр Ховд аймгийн 16 сум, Жаргалант сумын 12 багийн нийт 35 дээш насны 700 гаруй тамирчин оролцож хурд	100

				гаруй 23-аас дээш насны иргэдийг хамруулсан байна.		хүч , авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн байна. -Тамирчдын ур чадвар өсч спортоор хичээллэх иргэдийн тоо эрс нэмэгдсэн.	
1.11	Арга хэмжээ 11 “Хөгжөөнт буухиа “ биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах	Улсын төсөв 4 сая	Хамрагдсан байгууллага, хүний тоо	Хөгжөөнт буухиа тэмцээнийг бүх сумуудын иргэдийн дунд, аймгийн төвийн 12 багийн ард иргэдийн дунд зохион байгууллаа. Нийт 300 гаруй иргэд хамрагдсан	Байгууллагуудын дунд шигшээ тэмцээнийг зохион байгуулах	Жаргалант сумын 12 багийн иргэдийн дунд 2 дугаар сард зохион байгуулж явууллаа. Тэмцээнд 12 багийн 320 иргэн хамрагдлаа. 10 сард Жаргалант сумын 12 багийн ахмадуудын дунд зохион байгуулж 250 ахмад хамрагдлаа. - Иргэдийн чөлөөт цаг завьг зөв өнгөрүүлж дасгал хөдөлгөөн хийлгэж бие эрүүл мэндэд чухал ач тустай тэмцээн болсон.	100
1.12	Арга хэмжээ 12 Тамирчдын баярын үйл ажиллагааг зохион байгуулах	Улсын төсөв 3 сая	Хамрагдсан байгууллага , хүний тоо		Ахмад болон алдартай тамирчид, спортын зүтгэлтэн оролцуулах	Баярын арга хэмжээг 6 сарын 28-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлж спортын алдартан тамирчид, ахмад багш дасгалжуулагч, зүтгэлтэнгүүдийг урамшуулсан арга хэмжээг зохион байгууллаа.	100
1.13	Арга хэмжээ 13 Мөнгөлөг шагшуурга цас мөсний баярын спортын арга хэмжээг зохион байгуулах	Орон нутгийн төсөв 55 сая	Хамрагдсан байгууллага, хүний тоо	40.000 иргэд оролцлоо.	Иргэдийн дунд спортын арга хэмжээг зохион байгуулж, биеийн	Өвлийн спортын төрөлд “Мөнгөлөг шагшуурга-2024” цас мөсний баярыг /40.000 хүн	100

					тамир спортыг нийтэд сурталчлах , олон нийтийг татан оролцуулах	оролцлоо/ 1 сард амжилттай зохион байгууллаа. Мөсөн шагайн харваа, урианхай сурын харвааг бүсийн хэмжээнд уламжлал болгон зохион байгууллаа. Урианхай сурын харвааг брэнд болгохоор зорин олон улсын чанартай уралдаан тэмцээн зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	
Спортын сургалт-дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан, өсвөрийн шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг бүс, улс, олон улс, тив, дэлхий, олимпын түвшинд хүргэх							
Зорилт 2: Спортын сургалт, дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан өсвөр үеийн шигшээ багийн тамирчдын спортын амжилтыг улс, олон улс, тив, дэлхийн түвшинд хүргэх			Сургалт дасгалжуулалтын чанарт ахиц гарч төрийн ба төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа бэхжин тамирчдын ур чадвар, амжилт дээшилсэн байх	Аймгийн хэмжээнд 23 салбар холбоод, бүс, улс, олон улсаас медаль -380 дасгалжуулагч-8 байна.	Спортын тэмцээн уралдааны зохион байгуулалт сайжирч төрийн бус байгууллагуудын оролцоо нэмэгдэн тамирчдын амжилт ахиулах	2024 оны жилийн эцсийн байдлаар Олон улс, Тив, Дэлхий, Улс, Бүсийн аварга шалгаруулах тэмцээнээс 372 медаль хүртсэн байна.	84,6
2.1	Арга хэмжээ 1 Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийг байгуулж, залгамж халааг сайжруулах, шигшээ багийн спортын төрлийг нэмэгдүүлэх	Орон нутгийн төсөв	8 спортын төрлөөр шигшээ багийг байгуулсан байна.	-	2024 онд 8 спортын төрлөөр шигшээ багийг байгуулах	Аймгийн Засаг даргын дэргэд спортын 8 төрлөөр шигшээ баг байгуулж 685 тамирчин бэлтгэл сургуулилтаа тогтмол хийж байна. Шигшээ багийн дасгалжуулагчдын цалинг орон нутгийн төсөвт тусгуулан 113 сая төгрөгийг аймгийн Засаг	100

						<p>даргын нөөцөөс шийдвэрлэн олгож байна. Шигшээ багийн 8 дасгалжуулагчдыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, бичиг баримтыг бүрдүүлэн шалгалтын бэлтгэл ажлыг хангаж журмын дагуу 10 сард шигшээ багийн дасгалжуулагчдыг Чөлөөт бөх, Жүдо бөх, Ширээний теннис, Үндэсний бөх, Сагсан бөмбөг, Волейбол, Хөлбөмбөг, Байт харвааны төрлүүдээр сонгон шалгаруулан авч ажиллуулаад байна. Тэмцээн уралдааны зардлуудыг шийдвэрлэснээр тамирчдын амжилт өсч 2024 онд 372 медаль хүртсэн амжилттай байна.</p>	
2.2	<p>Арга хэмжээ 2 Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн спортын төрөл, тамирчин сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, мэргэжлийн нэгдсэн</p>	Орон нутгийн төсөв	Аймгийн Засаг даргын дэргэдэх шигшээ багийн тоо	Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах журам, дүрэм боловсруулан батлуулсан байна.	2024 онд өсвөрийн шигшээ багийн 8 спортын төрлийн дасгалжуулагчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах	<p>Шигшээ багийн тамирчдыг нөхөх сонгон шалгаруулалт хийгдэж 685 тамирчид бэлтгэл сургуулилтаа тогтмол хийж байна. 10 сард шигшээ багийн дасгалжуулагчдыг Чөлөөт бөх, Жүдо бөх,</p>	100

	удирдлага, зохион байгуулалтаар хангах					Ширээний теннис, Үндэсний бөх, Сагсан бөмбөг, Волейбол, Хөлбөмбөг, Байт харвааны төрлүүдээр сонгон шалгаруулан авч ажиллуулж байна.	
2.3	Арга хэмжээ 3 Хүүхэд, залуучуудын спортын авьяасыг илрүүлж шилдэг тамирчдын залгамж халаа бэлтгэх хүрээнд аймгийн хэмжээнд спортын наадам, аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг жил тутам зохион явуулах, зохион байгуулалтыг оновчтой болгох	Улсын төсөв 5 сая	Багийн спортын төрлөөр сурагчдын Лигийн тэмцээнийг цувралаар зохион байгуулах		Лигийн аварга шалгаруулах тэмцээнийг Сагсан бөмбөг, Волейболын төрлөөр зохион байгуулах	Сагсан бөмбөг, Волейболын төрлүүдээр амжилттай зохион байгуулагдаж давхардсан тоогоор 1200 гаруй хүүхэд оролцсон байна. Сагсан бөмбөгийн сурагчдын Лигийн аварга шалгаруулах тэмцээн 2024 оны 11 дүгээр сараас эхлэн цуварлаар амжилттай явагдаж байна.	100
2.4	Арга хэмжээ 4 Шинэ тутам хөгжиж буй спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж, хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын ажил үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	Улсын төсөв 1 сая -	Аймгийн хэмжээнд шинэ тутам хөгжиж буй спортын төрлийг хамрах хүрээг нэмэгдүүлнэ	Эрх зүйн орчин бүрдсэн, спортын төрлийн хамрах хүрээний судалгаа хийгдсэн	2024 онд нийтийн хүн амын 3 хувьд хүргэнэ. /2750/	Дардас, Ширээний шагайн спортын хөгжүүлэхээр техник тоног төхөөрөмжийг шинээр хийж бэлтгэн үйл ажиллагааг эхлүүлээ. 2024 онд ширээний шагай, дардасны спортыг хөгжүүлж тэмцээн уралдааныг багийн иргэд, ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн байгууллагын ажилтнуудын дунд	100

						<p>зохион байгуулж хэрэглэл материал, ширээ зэргийг стандартын дагуу хийж ашиглаж эхэлсэн. Ширээний шагайг спортыг ард иргэдэд сурталчилж Мөнгөлөг шагшуурга арга хэмжээний үеэр 380 гаруй ард иргэдэд үнэ төлбөргүй үйлчлэж сурталчиллаа. Ардын уламжлал шагайн наадгайн төрлөөр хичээллэх сонирхон тоглох иргэдийн тоо 10 хувиар нэмэгдэж байна. Шинэ тутам хөгжиж буй Дардасын спортыг хөгжүүлэх зорилгоор иж бүрэн тоног төхөөрөмж хоёрыг авч 2024 онд нийтийн биеийн тамирын арга хэмжээнд оруулж тэмцээнийг амжилттай зохион байгуулсан байна.</p>	
2.5	<p>Арга хэмжээ 5 Биеийн тамир, спортын ажил үйлчилгээний хүн амд үзүүлэх нэр төрлийг багийн спортын төрлөөр нэмэгдүүлж, орон нутагт хамрах хүрээг тэлэх</p>	<p>Улсын төсөв 1 сая</p>	<p>Багийн спортын төрлөөр хичээллэгчдийн хувийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Багийн спортоор хичээллэгчдийн тоо-8000</p>	<p>2023 онд 8 хувьд хүргэх</p>	<p>Волейбол, Хөлбөмбөг, Сагсан бөмбөг, ширээний теннисний спортын төрлүүдээр Ховд аймгийн хэмжээнд 58 секц дугуйланд 4800 гаруй өсвөр үеийн хүүхдүүд хичээллэж байна. Багийн спортоор</p>	100

						хүүхдүүд олноор хичээллэж эхэлснээр бүс, улсад гаргах амжилт өсч дээд лигт Ховд аймгийн 8 тамирчин оролцон тоглож өндөр түвшний тамирчид олноор төрөн гарч байна.	
2.6	Арга хэмжээ 6 Улс, бүсийн тэмцээнд баг тамирчдыг амжилттай бэлтгэн оролцуулах	Улсын төсөв 20 сая	Улс, бүсийн тэмцээнд баг тамирчдыг амжилттай бэлтгэн оролцуулна	2023 онд Бүс, Улсын аварга шалгаруулах тэмцээнд 17 спортын төрлөөр амжилттай оролцож 380 медаль хүртсэн амжилт үзүүлээд байна.	Спортын 18-с дээш төрлөөр Монгол улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 насны ангиллаар амжилттай оролцох	2024 онд аймаг орон нутагтаа Өндөр уулын авиралтын Альпинат-2024 улсын аварга шалгаруулах тэмцээн, өсвөрийн Чөлөөт бөх, Байт харвааны баруун бүсийн тэмцээн арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгууллаа. Спортын 5 төрлөөр бүсийн тэмцээнд оролцсон. Улсын аваргад спортын 23 төрлөөр 3 насны ангилалд амжилттай оролцож 372 медаль хүртсэн байна.	100
2.7	Арга хэмжээ 7 Аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулах	Улсын төсөв 20 сая	Аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг 23 спортын төрлөөр амжилттай зохион байгуулна	Спортын 17 төрлөөр 3 насны ангилалд 23 аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан байна. Тус тэмцээнүүдэд 3000 гаруй	Аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг 23 төрлөөр 3 насны ангилалд амжилттай зохион байгуулах	Спортын 18 төрлөөр 3 насны ангилалд 23 аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан байна. Тус тэмцээнүүдэд 7800 гаруй тамирчид оролцсон байна. Өсвөр үе, идэрчүүд, насанд	100

				тамирчид оролцсон		хүрэгчид, ахмад үеийн ангиллаар зохион байгуулсан.	
2.8	Арга хэмжээ 8 Өвлийн спортын их наадамд оролцох /БНХАУ-ын Шинжаан Уйгар/	Орон нутгийн төсөв	Оролцсон улс, хүний тоо	-	Цана, тэшүүрийн төрлөөр оролцох	БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай аймагт зохион байгуулагддаг олон улсын чанартай өвлийн наадамд тэшүүрийн төрлөөр 10 тамирчин амжилттай оролцсон.	100
2.9	Арга хэмжээ 9 Байт харвааны улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	Орон нутгийн төсөв 30 сая	Хамрагдсан аймаг дүүргүүд, хүний тоо	-	Монгол улсын аварга шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгуулах оролцох	Цуцлагдсан	
2.10	Арга хэмжээ 10 Хөлбөмбөгийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	Орон нутгийн төсөв 15 сая	Хамрагдсан байгууллага, хүний тоо	-	Бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг өсвөрийн насны ангиллаар амжилттай зохион байгуулах оролцох	Цуцлагдсан	
2.11	Арга хэмжээ 11 Байт харвааны баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	Орон нутгийн төсөв 7 сая	Хамрагдсан байгууллага, хүний тоо	-	Бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг идэрчүүдийн насны ангиллаар амжилттай зохион байгуулах оролцох	Тэмцээнд 5 аймгийн 50 гаруй тамирчид хүрэлцэн ирж оролцлоо. Ховд аймгийн эрэгтэй, эмэгтэй баг түрүүлээ. Нийт 7.5 сая төгрөгийн төсвөөр зохион байгууллаа. Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох болон аймгийн шигшээ багт тамирчдыг сонгон шалгаруулж авсан байна.	100

2.12	Арга хэмжээ 12 Чөлөөт бөхийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	Орон нутгийн төсөв 15 сая	Хамрагдсан байгууллага, хүний тоо	-	Бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг өсвөрийн насны ангиллаар амжилттай зохион байгуулах оролцох	5 аймгийн 480 тамирчид, өсвөр насны ангилалд 26 жинд амжилттай өрсөлдлөө. Тэмцээнд Ховд аймгийн тамирчид эрэгтэй эмэгтэй багаар дэд байранд шалгарсан байна. Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох аймгийн шигшээ багийг тэмцээнээс сонгон шалгаруулж авлаа. Чөлөөт бөхийн спортоор хичээллэгчдийн тоо 10 хувиар нэмэгдсэн.	100
2.13	Арга хэмжээ 13 Спортын байгууллагын баруун бүсийн уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулах	Орон нутгийн төсөв 6.5 сая	Хамрагдсан байгууллага, хүний тоо	Говь-Алтай аймагт зохион байгуулагдсан	Бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгуулах, оролцох	Спортын байгууллагын бүсийн тэмцээнд 5 аймгийн 90 албан хаагч оролцлоо. Спортын 5 төрлөөр шилдгүүдээ шалгаруулж туршлага солилцон хамтран ажиллаа.	100
Зорилт-3: Биеийн тамир, спортын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон төрөөс биеийн тамир, спортын талаар баримталж буй бодлого шийдвэрийг ханган мөрдөнө.							
			Төрийн албанд мөрдөгдөх хууль, тогтоол шийдвэр хэрэгжсэн байх	Үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомж, журмыг хэрэгжүүлэн ажиллах.	Төрийн байгуулагад мөрдөгдөх хууль, салбарын хууль тогтоомж, шийдвэр хугацаандаа бүрэн хэрэгжүүлэх	Биеийн тамир спортын байгууллагад мөрдөгдөх хууль тогтоомж, журмыг хугацаанд нь хэрэгжүүлэн ажиллаж байна.	99,4
3.1	Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалтуудыг		Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн	2023 онд 87 хувьтай үнэлэгдсэн.	Холбогдох заалт бүрийг хэрэгжүүлэх	Спортын аварга хөтөлбөр болон бусад заалтуудыг хэрэгжүүлж ажиллаа. Аймгийн Засаг	90

	хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах		холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх,			даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 84.7 хувийн биелэлттэй байна.	
3.2	Арга хэмжээ 2 Спортын амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад мөнгөн шагнал олгох, олимпын наадам, дэлхийн аварга, тив, улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчин, дасгалжуулагчдад аймгаас урамшуулал олгох	Орон нутгийн төсөв 30 сая	Олимпын наадам, дэлхийн аварга, тив, улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчин, дасгалжуулагчдад олгосон мөнгөн шагналын дүн, тоо	2023 онд амжилт гаргасан дасгалжуулагч, тамирчдын 57,9 сая төгрөгийн урамшууллыг даснаар олгосон байна.	Аймгаас ИТХ-ын тэргүүлэгчдээс баталсан Урамшууллын журмын дагуу тамирчин, дасгалжуулагч нарт мөнгөн урамшуулал олгох	Ховд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 11 сарын 3-ны өдрийн 67 дугаар тогтоолоор шинэчлэн боловсруулж батлууллаа. 2022 онд 47 сая төгрөгийн урамшууллыг олгосон 2023 оны тамирчин дасгалжуулагчдын урамшууллын 57,9 сая төгрөгийг дансаар олгосон байна. 2024 онд 64,6 сая төгрөгийн урамшууллыг тамирчид, дасгалжуулагч багш нарт дансаар олгож гарын бэлэг батламж гардууллаа.	100
3.3	Арга хэмжээ 3 Спортын аварга хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Орон нутгийн төсөв	Спортын аварга хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулна, хэрэгжүүлнэ.	Спортын аварга хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэн ажиллаж байна.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2024 онд спортын аварга хөтөлбөр 160 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан. 2024 онд Бүс, Улсын аварга шалгаруулах тэмцээнд 18 спортын төрлөөр амжилттай оролцож 372 медаль хүртсэн амжилт үзүүлээд байна.	100

						<p>Аймгийн нэр хүндийг өндөрт өргөх шилдэг өндөр зэрэглэлийн тамирчин бэлтгэх зорилгын хүрээнд: Аймгийн Засаг даргын дэргэдэх шигшээ багийг спортын 8-н төрлөөр тогтмол хичээллүүлж байна. Өсвөрийн шигшээ багт /Жүдо, Чөлөөт бөх, Волейбол, Сагсан бөмбөг, Ширээний теннис, Үндэсний бөх, Хөлбөмбөг, Байт харваа/ нийт 685 тамирчин тогтмол бэлтгэлд хамрагдаж бүс, улс, тив дэлхийн тэмцээнд амжилттай оролцсон.</p> <p>Үр дүн: 2024 онд аймаг орон нутагтаа Өндөр уулсын авиралтын улсын аварга шалгаруулах тэмцээн, өсвөрийн Чөлөөт бөх, Байт харвааны баруун бүсийн тэмцээн арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгууллаа. Энэ онд Ховд аймгийн тамирчид дэлхий, тив, улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож 64,6 сая</p>
--	--	--	--	--	--	--

						төгрөгийн урамшуулал тамирчин, дасгалжуулагч багш нар хүртэж байна.	
3.4	Арга хэмжээ 4 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжүүлэн, үнэлж дүгнэнэ.	-	Тухай жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр	2023 онд 94,3 хувьтай үнэлэгдсэн	Тайланг хуулийн хугацаанд дээд шатны харьяа байгууллагад хүргүүлэх	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир спортын улсын хорооны дарга, аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлтийг хагас бүтэн жилээр тооцож хүргүүлэн ажилласан.	100
3.5	Арга хэмжээ 5 Хууль, тогтоомж тогтоол шийдвэрийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангаж, явц үр дүнг тайлагнах	-	Тухай жилийн салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээгээр	2023 онд 91 хувьтай үнэлэгдсэн	Тайланг хуулийн хугацаанд дээд шатны харьяа байгууллагад хүргүүлэх	Хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг хагас бүтэн жилээр тооцон хуулийн хугацаанд дээд шатны байгууллагуудад хүргүүлж ажиллаа.	100
3.6	Арга хэмжээ 6 Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, албан хаагчдын ажиллах нөхцөл, чадавхыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах		Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан ажилтны тоо	Мэргэшүүлэх сургалтанд дасгалжуулагч хамруулсан 10	Мэргэшүүлэх сургалтанд дасгалжуулагч хамруулах 6	Байгууллагын дасгалжуулагчид ЗГТАБТСУХ-с зохион байгуулсан цахим сургалтууд мөн удирдлагын академиас 7 хоног бүрийн 4 дэхь өдөр зохион байгуулдаг төрийн албан хаагчийн сургалтуудад дасгалжуулагч нар бүрэн хамрагдсан.	100

						Спортын багш, дасгалжуулагч ажилтан албан хаагчдыг чадавхжуулах зорилгын хүрээнд 2024 онд онлайнаар болон танхимаар давхардсан тоогоор 63 сургалтанд 23 ажилтан хамрагдсан. /Шүүгч, Удирдлагын акедами, төрийн албан хаагчдын болон бусад/	
3.7	Арга хэмжээ 7 Монгол хэл, бичгийг анхан шатны сургалтанд байгууллага хамт олны хамруулах	Улсын төсөв 500 мянга	Монгол хэл, бичгийг анхан шатны сургалтанд байгууллага хамт олны хамруулах	10 сард анхан шатны сургалтанд бүх ажилчдыг хамруулсан	Байгууллагын бүх ажилчидад монгол бичгийн дунд шатны сургалтад хамруулах	Байгууллагын ажилчдын ажлын төлөвлөгөөнд тусгуулан ажиллаж байна. Цаст-Алтай сургуулийн багш Б.Цэцэгмаагаар 2 хоногийн монгол бичгийн анхан шатны давтан сургалт авч заалгалаа. Байгууллагын бүх ажилчид хамрагдлаа.	100
3.8	Арга хэмжээ 8 Улсын хэмжээнд мөрдөж байгаа спортын тэмцээн, наадмын зохион байгуулалтын журам, норм, норматив, стандартыг мөрдүүлэх, орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, удирдамж арга зүйн зөвлөмж хүргүүлэх	-	Стандартыг мөрдүүлэх, орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх		17 сум, төрийн болон төрийн бус байгууллагуудад стандартыг мөрдүүлж, орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ажиллах	Стандартыг мөрдүүлэн ажиллаж байна. Аймаг орон нутагтаа олон улсын шаардлагад нийцүүлэн Монгол улсын аварга шалгаруулах Альпинат авиралтыг амжилттай зохион байгуулсан. Бусад тэмцээн уралдааныг журам, дүрмийн дагуу зохин байгуулсан.	100

3.9	Арга хэмжээ 9 “Хариуцлагатай тунгалаг төр” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хугацаанд нь тайлагнана.	Үйл ажиллагааны зардлаар	Байгууллагын үйл ажиллагааг иргэдэд нээлтэй хүргэх, ажлын чанарыг дээшлүүлэх	2023 онд 100 хувьтай үнэлэгдсэн	Байгууллагын үйл ажиллагааг иргэдэд нээлтэй хүргэж мэдээ мэдээллийг тогтмол хүргэсэн байна. /100 хувьд хүргэнэ/	Аймгийн төрийн байгууллагуудын нэгдсэн Нээлттэй хаалганы өдөрт оролцож ард иргэдэд үйл ажиллагаагаа танилцуулж үйлчилгээ үзүүллээ. 1200 гаруй иргэдэд мэдээлэл өгч ажиллаа.	100
3.10	Арга хэмжээ 10 “Стандарттай Ховд” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хугацаанд нь тайлагнана.	Үйл ажиллагааны зардлаар	Стандартыг мөрдүүлэх, орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх		16 сумын спорт хамтлаг, спортын холбоод, спортын клубуудад стандартыг мөрдүүлж, орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ажиллах	Аймгийн төвийн болон Сумдад шинээр барьж байгаа спортын заалны барилгын явцад хяналт тавьж ажиллаж байна. 2024 онд спортын заал Алтай-30%, Дарви- 50%, Цэцэг-60% гүйцэтгэлтэй баригдаж байна. Жаргалант сумын Хайрхан, Бугат- 100%-ийн гүйцэтгэлтэй улсын комисс хүлээн авсан байна.	100
3.11	Арга хэмжээ 11 Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө боловсруулан батлаж ажиллана.			2023 онд 100 хувьтай хэрэгжүүлсэн	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловсруулан батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Ажилчдын ажлын хөлс, илүү цаг, ур чадварын нэмэгдлийг сар, улирал, хагас жил, жилийн ажлыг дүгнэж олгосон. Мөн эрүүл мэндийн үзлэг оношилгоо, эмчилгээнд	100

						хамруулах, дотоод журмын дагуу бусад үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан.	
3.12	Арга хэмжээ 12 Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллана.		Байгууллагад төлөвлөгөө боловсруулж ажиллах	2023 онд ёс зүйн зөрчилгүй ажилласан	Албан хаагчид зөрчил гаргаагүй ажиллах	2024 оны жил эцсийн байдлаар байгууллагын ажилчид төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм журмыг баримтлан ямар нэгэн зөрчилгүй ажиллаа.	100
3.13	Арга хэмжээ 13 Аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд оролцох цаг үеийн үүрэг хэрэгжүүлж ажиллана.		Шуурхай зөвлөгөөнд цаг баримтлаж оролцох	2023 онд аймгийн бүх шуурхай зөвлөгөөнд оролцсон	Удирдлагаас өгсөн үүрэг чиглэл бүрийг хэрэгжүүлэх	Аймагт зохион байгуулагдсан хурал зөвлөгөөнд 23 удаа оролцож аймгийн удирдлагуудаас өгөгдсөн үүрэг чиглэлийг бүрэн хэрэгжүүлж ажиллаа.	100
3.14	Арга хэмжээ 14 E-Mongolia дотоод удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлнэ.		Нэгдсэн системд бүртгүүлэн хэрэгжүүлэх	-	Байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэх	Биеийн тамир спортын үйл ажиллагаанд тамирчдын хаяг тогтоох, нас тогтоох, харьяа байгууллага зэргийг тодорхойлоход e.mongolia системийг нэвтрүүлэн ашиглаж байна. Мөн байгууллагын дотоод үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлтийн e.epr-mongolia программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.	100
3.15	Арга хэмжээ 15		Санхүүгийн мэдээллийг цаг тухай	Шилэн дансны мэдээллийг 1-12	Сар бүр мэдээллийг байршуулах	2024 оны жил эцсийн байдлаар байгууллагын	100

	Санхүүгийн сахилга хариуцлага дээшлүүлэн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангана.		бүрд нь мэдээллэх байршуулах	саруудад байршуулсан		санхүүгийн үйл ажиллагааг Шилэн дансанд 1-12 саруудад цаг тухайд нь байршуулж ажиллаа.	
3.16	Арга хэмжээ 16 Байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, хуулийн хугацаанд шуурхай хариу өгч ажиллана		Өргөдөл гомдол бүрийг хуулийн хугацаанд түргэн шуурхай шийдвэрлэх	2023 онд 11 өргөдөл гомдол ирсэн 100 хувьтай шийдвэрлэсэн	Хуулийн хугацаанд шийдвэрлэх	2024 оны жилийн байдлаар 25 өргөдөл бичгээр ирсэн хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг өгсөн. Ажилд орохыг хүссэн-14, цалинтай чөлөө хүссэн-2, ээлжийн амралт хүссэн-1, ажлаас чөлөөлөгдөхийг хүссэн-1, дотоод журмын дагуу тусламж хүссэн-3, бусад-4 өргөдөл ирсэн байна. Хугацаанд нь 100 хувь шийдвэрлэн ажилласан байна.	100

3.17	Арга хэмжээ 17 Байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, худалдан авах ажиллагаа, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангаж нээлттэй мэдээлж ажиллана.		Байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, худалдан авах ажиллагаа, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах	2023 онд ил тод байдлыг хангаж нээлттэй мэдээлсэн	Сар бүр мэдээллийг байршуулж ил тод байдлыг хангах	Мэдээллийг сар бүр байршуулан шинэчилж ажиллаа. 1-12 саруудад мэдээллээ байршуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна.	100
3.18	Арга хэмжээ 18 Байгууллагын жендерийн тэгш байдлыг хангаж ажиллана.		Байгууллагын жендерийн тэгш байдлыг хангах	2023 онд тэгш байдлыг хангаж ажилласан	Хууль, журамд нийцүүлж ажиллах	Холбогдож журам зааврын дагуу тэгш байдлыг ханган ажиллаж байна. Байгууллага 11 эрэгтэй, 13 эмэгтэй ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.	100
3.19	Арга хэмжээ 19 Авилгатай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.		Авилгатай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2023 онд спортын салбар авлигын зөрчилгүй ажилласан	Хууль журамд нийцүүлж ажиллах	Хууль журмын дагуу ажилтан албан хаагчдад мэдээллийг хүргэж ажиллаа. Байгууллагын хамт олон ямар нэгэн авилгын зөрчилгүй ажиллаа.	100
	Нийт үнэлгээ						92,8

Төлөвлөгөөг хянасан:
Ховд аймгийн Засаг дарга

Төсвийн Ерөнхийлөн захирагч
/М.Амарсанаа/
(огноо)

Төлөвлөгөөг тайлагнасан:
Биеийн тамир спортын газрын дарга

Төсвийн Шууд захирагч
/Ч.Түмэндэмбэрэл/
(огноо)
2024.12.10

